

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДСЭН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эд хөрөнгийг болзошгүй гал түймрийн аюулаас хамгаалах, галын аюулгүй байдлын үндсэн шаардлагыг тогтооход оршино.

1.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Галын аюулгүй байдлын хууль тогтоомж болон энэхүү дүрэм, галын аюулгүй байдлын норм, нормативийн бусад баримт бичгийг дагаж мөрдөнө.

1.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан нь галын аюулгүй байдлын хууль тогтоомж болон энэхүү дүрэм, галын аюулгүй байдлын норм, нормативийн бусад баримт бичгийг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

1.4. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 20.4-т заасны дагуу барилгын салбарын галын аюулгүй байдалтай холбоотой норм, нормативын баримт бичгийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөж барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, бусад салбарын галын аюулгүй байдлын дүрмийг холбогдох байгууллагатай зөвшилцөж онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус баталж мөрдүүлнэ.

Хоёр. Галын аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага

2.1. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, галын аюулгүй байдлыг хангуулах үүрэг бүхий албан тушаалтан нь тухайн байгууллагын барилга байгууламж, нутаг дэвсгэрийн хэмжээнд галын аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээнэ.

2.2. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн байгууллагын барилга байгууламж, объектын хэмжээнд галын аюулгүй байдлыг хангах дотоод зааврыг объект тус бүрээр баталж мөрдүүлнэ. Галын аюулгүй байдлыг хангах дотоод зааварт дараах асуудлыг тусгасан байна:

2.2.1. нутаг дэвсгэр, барилга байгууламж, өрөө тасалгаа, аврах зам, гарц;

2.2.2. галын аюултай ажил үйлчилгээ явуулах, тоног төхөөрөмж ашиглах, технологийн шат дамжлагын галын аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ;

- 2.2.3. тэсрэх, галын аюултай болон галын аюултай бодис, материалын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын дүрэм журам, зөвшөөрөгдөх хэм хэмжээ;
- 2.2.4. ил гал хэрэглэх, галтай ажил явуулах журам, тээврийн хэрэгслийн зам, гарц, тамхи татах байр;
- 2.2.5. шатах хог хаягдлыг хураах, хадгалах, зайлуулах шат дамжлага, ажлын тусгай зориулалтын хувцас хадгалах, цэвэрлэх журам;
- 2.2.6. ажлын дараа өрөө тасалгааг хааж үзлэг хийх журам;
- 2.2.7. шатдаг бодис, материалыг хадгалах, зайлуулах болон тусгай хувцас хэрэглэлийн эмх цэгцийг хангах арга хэмжээ;
- 2.2.8. өрөө тасалгаанд байх бүтэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний зөвшөөрөгдөх тоо хэмжээ;
- 2.2.9. тостой хувцас хадгалах, шатдаг хог хаягдал, тоосыг цэвэрлэх үе шат;
- 2.2.10. тэсрэх болон гал түймэр үүсэж болзошгүй орчин дахь хэмжих хэрэгслийн (даралт, дулаан хэмжигч г.м) хязгаарын үзүүлэлт;
- 2.2.11. объектод нэгэн зэрэг байх зөвшөөрөгдөх хүний тоо;
- 2.2.12. гал түймэр гарсан үед гал унтраах, аврах ангийг дуудах дараалал, тоног төхөөрөмжийг зогсоох, цахилгаан хангамж, агааржуулалт, салхивчийн тоног төхөөрөмжийг салгах, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг ашиглах, гал унтраах автомат тоног төхөөрөмж, дуут дохио, мэдээлэгч хэрэглэх, шатамхай материалыг аюулгүй газар зөөх, галын онц аюултай өрөө тасалгаанд үзлэг хийх чиг үүрэг, хийх ажил.
- 2.3. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн ажилтан бүрт галын аюулгүй байдлыг хангах талаар зааварчилгаа өгч, гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийг унтраах, гал түймэр гарсан үед аврах зам, гарц ашиглан хүмүүсийг аюулгүй газарт шуурхай нүүлгэн шилжүүлэх мэдлэг, чадвар олгох сургалтад хамруулж, дадлагажуулсан байна. Энэхүү сургалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж, уг үйл ажиллагааг баримтжуулсан байна.
- 2.4. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж (утаа зайлуулах систем, галын автомат систем, ус хангамж, галаас хамгаалах хаалт, хаалга, г.м)-ийг ашиглалтын байнгын бэлэн байдалд байлгана.
- 2.5. Барилга байгууламжид гал түймэр гарсан үед гарах аврах зам, гарцын төлөвлөлтийн зургийг харагдахуйц газар байрлуулсан байна.
- 2.6. Барилга байгууламжид гал түймэр гарсан үед мэдээлэх холбоо, дохиоллын хэрэгсэлтэй байна.

2.7. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн байршлыг тухайн барилга байгууламжийн төлөвлөлтийн зурагт тусгасан байна.

2.8. Орон сууцнаас бусад нэг дор 50-иас дээш хүн байрлах үйлдвэр, агуулахын барилга болон хүн олноор цуглардаг барилга байгууламжид гал түймрээс урьдчилан сэргийлэх техникийн комиссыг байгуулж болно.

2.9. Шөнийн цагаар хүмүүс тогтмол байрлах (24 цагийн хүүхдийн цэцэрлэг, дотуур байр, сургууль, эмнэлэг г.м) байгууллагад өдрийн болон шөнийн цагаар аврах үйл ажиллагаа явуулах хувилбарт төлөвлөгөөтэй байна. Эдгээр байгууллагын удирдлага нь гал түймэр гарсан үед тухайн барилга байгууламжид байгаа хүний тоог үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.

2.10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байнга байрлах барилга байгууламжийг гал түймрийн талаар шуурхай мэдээлэх тусгай (гэрлэн, дуут г.м) техник хэрэгслээр тоногдсон байна. Гэрлэн болон дуут дохионы хэрэгслийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд байрлаж байгаа өрөө бүрт, аврах зам, гарцын дагуу хаалга бүрт байрлуулна.

2.11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байнга байрлах барилга байгууламжид байрлуулсан гэрлэн дохионы хэрэгсэл нь дуут дохиотой хавсарсан, гэрлэн дохионы анивчих давтамж нь 5 Гц-ээс ихгүй байна. Гал түймрийн талаар мэдээлэх гэрэлтэж харагдах самбар нь хүний хараанд тохирсон тод ногоон гэрэлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байнга байрлах барилга байгууламжид ажиллах ажилтан нь гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийг унтраах, аврах ажиллагааны чиглэлээр тусгай сургалтад хамрагдаж, зааварчилгаа авсан байна.

2.12. Тэсэрч дэлбэрэх бодис, химийн аюултай бодис, материал боловсруулах, үйлдвэрлэх, хадгалах (газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун болон шатах хий түгээх станц зэрэг), ашиглах, тээвэрлэх, худалдаалах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага энэ тухайгаа онцгой байдлын байгууллагад мэдэгдэж, гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах, аврах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангасан байна.

2.13. Барилга байгууламж, задгай агуулах, галын гадна шат, гал унтраах автомашины усны эх үүсвэрт хүрэх зам гарц, хонгил, нүхэн гарц нь автомашин явах бүрэн бололцоотой, өвлийн цагт цас, мөснөөс цэвэрлэгдсэн байнгын бэлэн байдалд байна.

2.14. Гал унтраах автомашин явах зам, гарцыг түр хугацаагаар хаах шийдвэр гаргасан албан тушаалтан энэ талаар тухайн төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагад мэдэгдэж, зам, гарцыг хаасан хугацаанд тойрч гарах замын чиглэлийг зааж, саадыг даван гарах боломжоор хангаж, усны эх үүсвэрт хүрэх гарцыг гаргасан байна.

2.15. Галын аюулгүйн шаардлагын дагуу барилга байгууламжийн мод, төмөр, хийц бүтээц, даавуу, хөшиг зэрэг шатамхай эд зүйлийг галд тэсвэртэй бодист түрхлэг, нэвчилгээ хийсэн байх бөгөөд тухайн бодисын үйлчлэлийн хугацаа дууссаны дараа дахин боловсруулалт хийнэ. Галд тэсвэртэй бодисын үйлчлэлийн чанарыг техникийн үзүүлэлтэд заасан хугацаанд болон жилд 1 удаа шалгана.

2.16. Инженерийн болон технологийн шугам сүлжээний хаалт, хучилтад үүссэн завсар, нүхийг галын дөл, утаа, хий нэвтрэхээс хамгаалсан галд тэсвэртэй материалаар битүүлсэн байна.

2.17. Барилга байгууламжийг түрээслэх гэрээнд тухайн барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг хангах шаардлага, хариуцлагын талаар заавал тусгана.

2.18. Барилгын дотоод өөрчлөлт, засварын үр дүнд гал унтраах автомат систем, галын дохиоллын үйлчлэх хүрээг багасгах зайлшгүй шаардлагатай тохиолдолд гал түймрийн улсын хяналтын байцаагчтай зөвшилцөж хамгаалалтгүй болсон талбайд нэмэлт гал унтраах автомат унтраагуур, мэдээлэгч суурилуулна.

2.19. Барилга байгууламжийн аврах зам, гарцыг тухайн барилгад байрлах хүний тоог харгалзан төлөвлөж, аврах зам, гарцын өргөний хэмжээг аврах ажиллагаа явуулах хугацааны шаардлагыг хангахуйц байдлаар тогтооно.

2.20. Технологийн нөхцөлөөр олон хүн байх шаардлагагүй, дээврийн хөндий, техникийн давхар, зоорийн давхрын хаалгыг цоожтой байлган, түлхүүр хадгалсан газрын мэдээллийг хаалган дээр зааж өгсөн байна. Эдгээр газрын цонхыг шиллэсэн, байнга хаалттай байна.

2.21. Зоорийн болон хагас зоорийн давхрын цонхны гаднах зай, нүх нь хог хаягдалгүй цэвэрхэн, зайлшгүй шаардлагаар төмөр хаалт, тор хийсэн бол дотроосоо түлхүүргүй онгойхоор хийгдсэн байна.

2.22. Зоорийн болон хагас зоорийн давхрын аврах зам гарц, шатны хонгил, өрөө, хана, таазны гоёл чимэглэл, зар сурталчилгааны тоног төхөөрөмж нь галд тэсвэртэй материалаар хийгдсэн байна.

2.23. Барилга байгууламжийн зоорийн болон хагас зоорийн давхарт үйлчилгээ явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллага нь 5л-ээс бага хэмжээтэй 1 ширхэг хийн баллоныг тухайн нутаг дэвсгэрийн гал түймрийн улсын хяналтын байцаагчийн зөвшөөрөлтэйгээр ашиглаж болно.

2.24. Эвдрэл гэмтэлтэй шатдаг хийн тоног төхөөрөмж ашиглах, ахуйн зориулалттай хийн тулга болон тосон дэн, дэнлүү, зул, лаа нь унахааргүй суурьтай, доошоо халах бололцоогүй хийцтэй байх бөгөөд модон эдлэл зэрэг шатдаг материалаас хажуу тийш 0.2м, доош 0.7м-ээс илүү зайтай байрлуулахыг хориглоно.

2.25. Шатах хий, шингэнээр (түлшээр) цэнэглэдэг гэр ахуйн хэрэгслийг ашиглахдаа үйлдвэрээс гаргасан аюулгүй ажиллагааны шаардлагыг чанд мөрдөнө.

2.26. Түлшээр цэнэглэх халаагч, гэрэлтүүлэгч хэрэгслийг өөр төрлийн шатах шингэнээр (бензин, спирт г.м) цэнэглэхийг хориглоно.

2.27. Тос, шатах шингэн болсон ажлын хувцсыг тусгайлсан газарт байрлуулсан металл шүүгээнд өлгөж хадгална.

2.28. Хоёр болон түүнээс дээш давхар бөгөөд гаднах шилэн ханатай барилгад давхар тус бүрийн түвшинд байрлуулсан утаа үл нэвтрэх хаалтын хийцийг өөрчлөхийг хориглоно.

2.29. Түр ашиглах барилгыг (барилгын ажилчдын түр байр, чингэлэг, худалдааны цэг г.м) галын аюулгүй байдлын норм, нормативт өөрөөр заагаагүй бол барилга байгууламжаас 15 м-ээс багагүй зайд, эсхүл гал эсэргүүцэх хананы талд байрлуулна.

2.30. Бие даасан жижиг блок-чингэлгэн байр болон гэрийг нэг дор 10-аас ихгүй, нийт талбай нь 800 кв.м-аас ихгүй байхаар бүлэглэн бүлэг бүрийн хооронд болон бусад барилга, худалдаа, үйлчилгээний цэг зэргээс 15м-ээс багагүй зайтай байхаар байрлуулна.

2.31. Хог болон цагаан хэрэглэл дамжуулах галд тэсвэртэй хоолой нь зураг төсөлд тусгагдсаны дагуу хавхлаг хаалттай байна. Хавхлага нь байнга хаалттай, бүрэн бүтэн, жийргэвч сайтай байх шаардлагатай.

2.32. Хог цуглуулах өрөөний хаалгыг байнга цоожтой байлгана. Хог цуглуулах өрөө, дамжуулах сувагт гарсан гал түймрийг унтраах зориулалтын шугам хоолойтой байна. Хогийн цэгт хог дамжуулах хоолой руу галтай эд зүйл болон тэсэрч дэлбэрэх, шатдаг бодис, материал, эд зүйл хийхийг хориглоно.

2.33. Барилга байгууламжид гал түймэр гарсан үед ашиглах зориулалттай цахилгаан шатыг ажиллуулах, ашиглах зааврыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

2.34. Цахилгаан шат нь гал түймэр гарсан үед барилгын 1 дүгээр давхарт автоматаар зогсож хаалга нь нээлттэй байхаар хийгдсэн байна.

2.35. Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор барилга байгууламжид дараах зүйлийг хориглоно:

2.35.1. барилга байгууламжийн хоорондох галын аюулгүйн зайг бараа материал хураах, автомашины зогсоол болгох зэргээр ашиглах;

2.35.2. барилга байгууламжийн ойр орчимд хялбар авалцан асах шатамхай шингэн, шахсан болон шингэрүүлсэн хийн савыг хяналтгүйгээр орхих;

2.35.3. технологийн горимыг нь хэмжих хяналтын төхөөрөмж нь салгаатай, эсхүл эвдрэл гэмтэлтэй тоног төхөөрөмжийг ажиллуулах;

2.35.4. зоорийн болон хагас зоорийн давхарт дүрмээр зөвшөөрөгдсөнөөс бусад шатамхай болон хялбар авалцан асах шингэн, дарь, тэсэрч дэлбэрэх бодис, материал, хийн баллон зэрэг галын аюултай бодис, материалыг хадгалах, хэрэглэх;

2.35.5. дээврийн хонгил, техникийн давхар, салхивчийн камерын өрөө, шатны хөндий зэргийг үйлдвэрлэл, засвар хийхэд ашиглах, тэдгээрт шатамхай материал, тоног төхөөрөмж, үйлдвэрийн бүтээгдэхүүн хадгалах;

2.35.6. цахилгаан урсдаг шатны өмнөх талбай, шатны талбай зэрэгт худалдаа болон бусад ажил, үйлчилгээ явуулах, агуулахын зориулалтаар ашиглах;

2.35.7. зоорийн болон хагас зоорийн давхраас бие даасан гарцгүй, эсхүл гарц нь барилгын үндсэн шатнаас галаас хамгаалах хаалтаар тусгаарлагдаагүй тохиолдолд тухайн барилга байгууламжид аж ахуйн зориулалтын үйлдвэрлэл явуулах;

2.35.8. давхрын хонгил, үүдний өрөө, шатны хонгил, тавцангаас аврах зам, гарц руу гал тархах хүчин зүйлээс хамгаалах зорилгоор хийсэн галд тэсвэртэй хаалгыг өөрчлөх, авах;

2.35.9. барилгын дотор зохион байгуулалт, өрөө тасалгаа, байр байршлын өөрчлөлт хийснээр хүмүүсийг аврах үйл ажиллагаа удаашрах, гал түймэр унтраах багаж хэрэгсэл, усан хангамжид хүрэх бололцоо хумигдах, гал унтраах автомат төхөөрөмжийн унтраах талбай багасах тохиолдолд барилгын дотоод засвар, өөрчлөлт хийх;

2.35.10. гадна аврах шат, тагт хоорондын шатны талбай, хавхлага хаалт, дамжин өнгөрөх зам, аврах зам гарцыг хаах, гарцын талбайг багасгаж эд зүйл хураах, байрлуулах;

2.35.11. өрөө тасалгаа, хувцас хэрэгслийг бензин, түлш зэрэг шатах бодис, материалаар цэвэрлэх, угаах, хөлдсөн шугам хоолойг ил гал, бамбар, гал үлээгчээр гэсгээх (зөвхөн халуун ус, элс уураар гэсгээнэ);

2.35.12. ажлын байранд цэвэрлэгээний тостой материалыг орхих;

2.35.13. зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд барилгын давхрын болон зоорийн давхрын цонх, салхивчийг төмөр тороор хааж гагнах;

2.35.14. утааждаггүй шатны хонгил руу орох тагт, хаалгыг шиллэх;

2.35.15. шатны тавцан, давхрын хонгилд эд зүйл агуулах, шатны доорх талбайд шатах материал, эд зүйл хураах (шатны доорх талбайд шатдаггүй материалаар хийсэн ханаар тусгаарлан төвийн дулаан, ус хэмжих болон цахилгаан хуваарилах удирдлагын самбар байрлуулж болно);

2.35.16. хаалганы онгойх чиглэлийг өөрчилж аврах зам гарц руу хүрэх болон зэргэлдээ өрөөнөөс гарахад саад учруулах, өрөө тасалгаанаас нийтийн хонгил, шатны тавцан руу гарах чиглэлд барилгын зурагт тусгаагүй хаалга нэмж хийх;

2.35.17. үйлдвэрийн болон агуулахын зориулалттай (галд тэсвэршилтийн Ү зэргээс бусад) барилга дотор болон гадна өргөтгөлийг Ш4 төрлийн материалаар хийх;

2.35.18. олон хүн байрлах барилгын дотоод засал чимэглэлд шаталтын нөлөөгөөр амьсгал боогдуулах хорт хий ялгаруулдаг барилгын материал ашиглах.

2.36. Барилга байгууламжийн аврах зам, гарцыг ашиглахад дараах зүйлийг хориглоно:

2.36.1. аврах зам, гарц, хаалгыг хааж (хонгил, гарц, үүдний өрөө, цахилгаан шатны талбай, шатны тавцан, дээвэрт гарах гарц, хаалга зэргийн) төрөл бүрийн хог хаягдал, бараа материал, эд зүйл хураах, тоног төхөөрөмж байрлуулах, хаалгыг онгойхгүйгээр бэхлэх;

2.36.2. барилгын үүдний өрөөнд (хувийн орон сууцнаас бусад) хувцас хатаах хадгалах хатаагуур, өлгүүр, шүүгээ, бусад эд зүйл байрлуулах, түр хадгалах;

2.36.3. аврах зам, гарц дээр (хаалганы нээлхийг таглаж), хөдөлгөөнт, сөхөж буулгадаг, эргэдэг хаалга, хаалтыг байрлуулж гарах хөдөлгөөнд саад учруулах;

2.36.4. аврах зам, гарцын хана, тааз, шаланд (Ү зэргийн галд тэсвэршилттэй барилгаас бусад) өнгөлгөө, будаг, гадаргуу, дэвсгэр хийхдээ галын аюулгүйн норм, нормативийн баримт бичигт зааснаас бусад материал ашиглах;

2.36.5. гал түймэр гарсан үед автоматаар хаагддаг хаалт, хаалганы зориулалтыг өөрчлөх, авах;

2.36.6. утааждаггүй шатны хонгилын агаарын бүсийг хааж хаалт хийх, шиллэх;

2.36.7. төмөр тортой шилэн хаалгыг ердийн шилтэй хаалгаар солих.

2.37. Аж ахуйн нэгж, байгууллага, галын аюулгүй байдлыг хариуцсан ажилтан гал түймэр гарсан үед гал түймэр унтраах, аврах анги хүрэлцэн иртэл дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

2.37.1. хүний амь насанд аюул учирсан бол өөрт байгаа техник хэрэгсэл, багаж төхөөрөмжийг ашиглан аврах ажиллагаа явуулах;

2.37.2. галын мэдээллийн систем, гал унтраах автомат систем, утаа зайлуулах систем ажиллаж эхэлсэн эсэхийг шалгах;

2.37.3. шаардлагатай бол (гал түймрээс хамгаалах, гал унтраах автомат системээс бусад) цахилгаан эрчим хүчийг салган тоног төхөрөмжийг унтраах, түүхий эд, хий, уур зэрэг гал түймрийг дэмжих технологийн ажиллагааг зогсоох (зарим онцгой тохиолдолд үйлдвэрийн технологийн процесс, онц чухал объектын тоног төхөөрөмжөөс бусад);

2.37.4. гал унтраахад оролцож байгаагаас бусад ажилчдыг аюултай бүсээс холдуулах;

2.37.5. гал унтраах анги иртэл гал унтраах үйл ажиллагааг зохион байгуулах;

2.37.6. гал унтраах үйл ажиллагаанд оролцож байгаа болон бусад ажилчдынхаа аюулгүй байдлыг хангах;

2.37.7. гал унтраах ажиллагаатай хамт хүмүүс, эд зүйл, тоног төхөөрөмжийг аврах, хамгаалах ажиллагаа явуулах;

2.37.8. гал унтраах ангийг угтан авах ажлыг зохион байгуулан зам гарцыг зааж чөлөөлөн гал унтраахтай холбоотой тодорхой мэдээлэл, зураг схемээр хангах;

2.37.9. гал унтраах ангийн удирдагчийг барилгын хийц бүтээц, технологийн онцлог, шатамхай болон тэсэрч дэлбэрэх бодис, материалын хэмжээ, байрлал, гал унтраах төлөвлөгөө, шуурхай карт зэрэг галыг шуурхай унтраахад шаардлагатай мэдээллээр хангах, томилгоот галын бүлгэм, хүн хүчээс бүрдсэн ажлын хэсгийг гарган өгч хамтран ажиллах.

2.38. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагч гал түймэр гарч байхыг харсан, эсхүл гал түймэр гарсан байж болзошгүй шинж тэмдэг (утаа гарах, үнэртэх, орчны дулааны хэм ихсэх гэх мэт) илрүүлсэн тохиолдолд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

2.38.1. энэ тухай 101 тоот утсаар яаралтай мэдэгдэнэ. Мэдээллийг өгөхдөө нэрээ хэлж, хаана гал түймэр гарч байгаа талаар хаяг, ямар барилга, юу шатаж байгааг болон тухайн шинж тэмдгийг хэлнэ.

2.38.2. тухайн байгууллагын удирдлага, харуул, жижүүрт мэдэгдэнэ. Боломжтой тохиолдолд хүмүүс, эд зүйлийг аврах, галыг унтраах арга хэмжээ авна.

Гурав. Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах үед баримтлах галын аюулгүй байдлын шаардлага

3.1. Олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулж байгаа байгууллага нь арга хэмжээ, үзвэр үйлчилгээг зохион байгуулахаас өмнө тухайн объектын галын аюулгүй байдлыг шалгаж, аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.

3.2. Өрөө, танхимд үзэсгэлэн гаргах зорилгоор барилгын дотоод байршил, тоног төхөөрөмжид өөрчлөлт хийхдээ шат, аврах бусад гарц руу очих зам гарцыг хаах, нэвтрэх зайг багасгахыг хориглоно.

3.3. Олон хүн нэг дор байрлах барилга байгууламж нь цахилгаан тасарсан тохиолдолд ослын гэрэлтүүлэг, дуут мэдээлэгчтэй байх бөгөөд объектын онцлог, багтаамж, барилгад байгаа хүмүүсийн тооноос хамааруулан тооцож гар чийдэн байрлуулна. Барилга байгууламжийн харуул хамгаалалтын бүрэлдэхүүн нь иж бүрэн гэрэлтүүлэх хэрэгслээр хангагдсан байна.

3.4. Олон хүн байрлах барилгын шал болон шатанд дэвссэн хивс, хивсэнцэр нь сайтар бэхлэгдсэн байна.

3.5. Аврах зам, гарцад байрлах “аврах гарц”, “аврах хаалга” зэрэг гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ нь тэжээлд байнга залгаж асаалттай байх бөгөөд үзвэрийн газарт танхимаас хүмүүс гарсны дараа унтрааж болно.

3.6. Аврах зам, гарцын гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ нь цахилгаан тасармагц ослын тэжээлээс (өөр эх үүсвэрээс) тэжээгдэн автоматаар асч байхаар тоноглогдсон байна.

3.7. Талбайн болон тайзны гэрэлтүүлгийг суурилуулан ашиглах тохиолдолд шатдаг материалд ойр байрлуулахыг хориглоно.

3.8. Гэрэлтүүлэг, чийдэнг шатдаг материалаас 0.5 м, линзтэй гэрэлтүүлгийг 2 м-ээс багагүй зайтай байрлуулна. Тэдгээрийн гэрэл шүүгч нь шатдаггүй материалаар хийгдсэн байна.

3.9. Олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахдаа галын аюулгүйн шаардлагад нийцсэн 2-оос доошгүй аврах зам, гарцтай, цонх нь төмөр хаалтгүй байна. Давхар дундын хучилт нь шатдаг материалаар хийгдсэн тохиолдолд нэг, эсхүл хоёр давхарт байрлах танхимыг сонгоно.

3.10. Нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах үед байр, танхим болон тайзны үзлэгийг тогтмол хийж, арга хэмжээ дууссаны дараа барилга байгууламжид дахин үзлэг хийж жижүүрт хүлээлгэн өгнө.

3.11. Шинэ жилийн арга хэмжээний үед сүлд модыг зам гарц, хаалганы дэргэд байрлуулахыг хориглох бөгөөд мөчрийг хана, таазнаас 1 м-ээс доошгүй зайтайгаар бат бэх суурилуулсан байна.

3.12. Гэрэлтүүлэг, чимэглэл нь цахилгаан байгууламжийн дүрэм, журамд бүрэн нийцсэн байна.

3.13. Галын аюулгүйн дүрэмд тусгайлан зөвшөөрөөгүйгээс бусад тохиолдолд аврах зам, гарцын дагуу байрлах хаалга нь барилгаас гарах чиглэлийн дагуу онгойхоор төлөвлөгдсөн байна.

3.14. Аврах зам дахь хаалга нь дотор талаасаа түлхүүргүй чөлөөтэй онгойхоор байна.

3.15. Олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах үед дараах зүйлийг хориглоно:

3.15.1. гал түймэр гарах нөхцөл бүрдүүлэх, ил гал, галт сум, улайсагч гэрэлтүүлэг, дэнлүү, пиротехник зэргийг ашиглах;

3.15.2. галын болон тэсрэх аюултай үйл ажиллагаа (гагнуур, будаг зэрэг) явуулах;

3.15.3. өрөөний гэрэлтүүлгийг бууруулах зорилгоор цонхонд бууруулагч хальс, хаалт хийх;

3.15.4. үзвэрийн танхимын суудал хоорондын зай хэмжээг багасгах, нэмж илүү суудал тавих;

3.15.5. арга хэмжээний үеэр танхимын гэрлийг бүрэн унтраах;

3.15.6. тогтоосон хэмжээнээс илүү хүн танхимд оруулах.

3.16. Гадаадын иргэн, аж ахуй нэгж, байгууллага хоёр улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу, эсхүл бие даан үзэсгэлэн, үзвэр, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахдаа Монгол Улсад мөрдөж байгаа галын аюулгүй байдлын дүрмийн шаардлагыг дагаж мөрдөнө.

3.17. Соёл урлаг, спорт, түүх дурсгал, шашны байгууллага, үзвэрийн газар нээлтийн үйл ажиллагаа эхлэхийн өмнө галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа эсэхээ мэргэжлийн байгууллагаар шалгуулж илэрсэн зөрчлийг арилгасан байна.

Дөрөв. Цахилгаан болон хийн тоног төхөөрөмж, зуух ашиглах үед баримтлах галын аюулгүй байдлын шаардлага

4.1. Цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан шугам сүлжээ, цахилгаан хэрэгслийн угсралт, ашиглалт, техникийн үйлчилгээ, хяналтыг тэдгээрийн дүрэм, журамд заасны дагуу мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэнэ.

4.2. Цахилгаан тоног төхөөрөмжийг ашиглаж дууссаны дараа гал түймрээс хамгаалах болон ослын гэрэлтүүлгээс бусад төхөөрөмжийг хүчдэлээс бүрэн салгана. Бусад цахилгаан тоног төхөөрөмж, ахуйн цахилгаан хэрэгслийг тэдгээрийн ашиглалтын баримт бичигт заасан тохиолдолд хүчдэлээс салгахгүй орхиж болно.

4.3. Цахилгаан дамжуулах агаарын шугамыг шатдаг бараа материал, эд зүйл, задгай агуулахын дээгүүр татах, эсхүл шатдаг материалаар хийгдсэн дээвэр дээр дамнуулан татахыг хориглоно.

4.4. Аянгын хүчтэй үйлчлэлийн бүсэд байрласан барилга байгууламж нь барилгын норм, дүрмийн шаардлагыг хангасан аянгаас хамгаалах төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

4.5. Цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, хөдөлгүүр, цахилгаан дамжуулах утсыг орчны нөхцөл, үйлдвэрийн галын болон тэсрэх аюулын зэрэгт тохируулан сонгон хэрэглэнэ.

4.6. Барилга байгууламжийн угсралт, засварын ажлаас бусад нөхцөлд цахилгаан шугамыг түр хугацаагаар тавьж ашиглахыг хориглоно.

4.7. Шатдаг материалаар хийсэн хайрцаг, сав, баглаа боодол бүхий бүтээгдэхүүн ашигладаг үйлдвэр, агуулахын барилгад шилэн бүрхүүл бүхий хамгаалалттай цахилгаан гэрэлтүүлэг хэрэглэнэ.

4.8. Ашиглаж байгаа цахилгаан шугаманд шинээр хэрэглэгч холбохдоо техник хяналтын тооцоог үндэслэн зөвхөн цахилгааны аюулгүй байдлыг хариуцсан байгууллагын шийдвэрээр гүйцэтгэнэ.

4.9. Барилгад цахилгаан дамжуулах утсыг ил татахдаа механик гэмтэл учирч болох хэсгүүдэд төмөр хоолой болон нэмэлт хамгаалалт хийнэ.

4.10. Цахилгааны шугам, утсыг инженерийн шугам сүлжээ, утааны яндан, халуун усны хоолойтой зэрэгцүүлэн ил, далд байдлаар татаж ашиглахыг хориглоно.

4.11. Цахилгаан тоног төхөөрөмжийг ашиглах үед дараах зүйлийг хориглоно:

4.11.1. дамжуулагчийн тусгаарлагч нь шалбарч гэмтсэн, ашиглалтын явцад тусгаарлах чанараа алдсан шугам, дамжуулагч утсыг ашиглах;

4.11.2. хүчдэлд тохироогүй чанарын шаардлага хангахгүй гал хамгаалагч хэрэглэх;

4.11.3. цахилгаанаар халах хэрэгслийг шатдаг материалаар хийсэн суурьтай ашиглах, хяналтгүй орхих;

4.11.4. барилга байгууламжийг халаах зорилгоор стандарт бус цахилгаан зуух, бусад төхөөрөмж ашиглах;

4.11.5. цахилгаан гүйдэл бүхий кабель шугам, дамжуулах утасны хамгаалалтгүй үзүүрийг ил орхих;

4.11.6. гэмтэлтэй цахилгаан хэрэгсэл ашиглах;

4.11.7. цахилгаан дамжуулах утсыг хадаасаар бэхлэх, хаалганы хавтасны завсараар гаргах, цахилгааны утас, унтраалгаас эд зүйл өлгөх;

4.11.8. гэрлийн чийдэнгийн шилийг цаас, өөр төрлийн шатдаг материалаар ороох;

4.11.9. цахилгааны хянах самбар, цахилгаан хөдөлгүүр, асааж унтраах аппаратын дэргэд шатамхай (хялбар авалцан асах) бодис, материал байрлуулах, хураах.

4.12. Агаар сэлгэлтийн хоолой дахь гал баригч (хаалт, хавхлага зэрэг), галын автомат дохиоллын систем, гал унтраах болон гал түймрийн үед автоматаар агаар сэлгэлтийг салгадаг төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлгана.

4.13. Агаар сэлгэлтийн болон кондиционерын системийг ашиглахад дараах зүйлийг хориглоно:

4.13.1. агаар сэлгэлтийн систем байрлах өрөөний хаалгыг нээлттэй орхих;

4.13.2. сорох суваг, хоолой, торыг хаах;

4.13.3. агааржуулалтын хоолойд хийн халаах хэрэгслийг холбох;

4.13.4. агааржуулалтын хоолой дахь тос, тоос гэх мэт бохирдлыг шатааж цэвэрлэх;

4.14. Агаар сэлгэлтийн системийн хоолой, холбоос, нугалаа, хаалт зэрэг эд ангийг жилд 1 удаа техникийн үйлчилгээнд хамруулна.

- 4.15. Галын болон тэсэрч дэлбэрэх аюултай өрөө тасалгааны агаар сэлгэлтийн системийг ашиглалтын баримт бичигт заасан зааврын дагуу цэвэрлэнэ.
- 4.16. Галын болон тэсэрч дэлбэрэх аюултай өрөө тасалгааны агаар сэлгэлтийн систем, тоос баригч, хий шүүгч нь гэмтэлтэй, эсхүл салгаатай тохиолдолд тухайн өрөө тасалгаанд технологийн тоног төхөөрөмж ажиллуулахыг хориглоно.
- 4.17. Галын болон тэсэрч дэлбэрэх аюултай өрөө тасалгааны агаар сэлгэлтийн системийн сэнсэнд шатамхай тоос, бусад хог орохоос сэргийлэх хамгаалалт, хаалт хийсэн байна.
- 4.18. Хялбар авалцан асах шингэн, шатамхай шингэнийг усны шугам сүлжээ рүү хийх, асгахыг хориглоно.
- 4.19. Шатах тослох материалыг зөвшөөрөгдсөн хэмжээгээр газар доорх хонгилоор зөөвөрлөх, тээвэрлэхэд гал унтраах анхан шатны багаж хэрэгслээр хангасан байна.
- 4.20. Хийгээр ажилладаг ахуйн хэрэгсэл (хийн зуух, ус халаагч, хий түгээгч), хийн баллоныг галын аюулгүйн дүрмийн дагуу барилгын гадна талд барилга, зоорийн болон хагас зоорийн давхрын орцноос 5 метрээс дотогш зайд байрлуулан хийн баллоныг шатахгүй материалаар хийгдсэн тусгай саванд (баллоны дээд хэсэг, редукторыг хаасан шүүгээ, гэртэй) хийж, барилгын битүү хана бүхий талд байрлуулна.
- 4.21. Хийн баллон хадгалах тусгай сав нь цоожтой, агаар сэлгэлтийн хавхлагатай байх бөгөөд “Галын аюултай. Шатдаг хий” гэсэн анхааруулах тэмдэгтэй байрлуулсан байна.
- 4.22. Барилга байгууламжийн өрөө тасалгаа болон орон сууцны зориулалтын барилгын үүдэнд хийн баллон байрлуулсан бол “Галын аюултай. Хийн баллон” гэсэн анхааруулах тэмдэг байрлуулсан байна.
- 4.23. Шатах хий хэрэглэдэг тоног төхөөрөмж ашиглах тохиолдолд дараах зүйлүүдийг хориглоно:
- 4.23.1. хий алдаж байгаа тоног төхөөрөмж ашиглах;
- 4.23.2. хий дамжуулах төхөөрөмжийн холболтыг оч үүсгэх багаж ашиглан хийх;
- 4.23.3. холбоосын битүүмжлэлийг ил гал (лаа, шүдэнз, асаагуур г.м) ашиглан шалгах.
- 4.24. Хийн тулгыг 2.2 метрээс дээш өндөр таазтай, агаар сорох суваг болон салхи оруулах цонхтой галлагаа хэрэглэдэггүй байранд барилгын халаах хэрэгслээс 1 метр, цахилгаан халаагчаас 3 метр зайтай байрлуулна.
- 4.25. Хийн зуухыг ажиллуулахын өмнө шатах камер, утааны сувгийг агааржуулж, хийн индикатороор агаарын орчинг шалгана.

4.26. Хийн түлш ашигладаг барилгын агааржуулах сувгийг улиралд 1-ээс доошгүй удаа цэвэрлэж, агааржуулалтын системийг жилд 2-оос доошгүй удаа шалгаж, зохих засвар үйлчилгээг хийнэ.

4.27. Амины орон сууц болон барилга байгууламжид хийн баллон ашиглах тохиолдолд “Хийн баллон-Галын аюултай” гэсэн тэмдэглэгээг орох хаалганы дэргэд байрлуулсан байна.

Тав. Ой хээрийн бүсэд баримтлах галын аюулгүй байдлын шаардлага

5.1. Ой, хээрийн бүсэд байрлах амралт, сувилал, аялал жуулчлал, хүүхдийн зуслангийн газар нь галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгээр тогтоосон гал түймэр унтраах техник хэрэгсэл, усан хангамжтай байна.

5.2. Ой хээрийн бүс дэх модон гүүр нь эргэн тойрон 1,4м-ээс багагүй өргөнтэй эрдэсжүүлсэн бүсээр хөвөөлөгдсөн байна.

5.3. Гүүрний доорх газрын 50м-ийн радиуст хамаарах хэсгийн хуурай өвс, бут сөөг, шатамхай хог хаягдлыг тухай бүр цэвэрлэнэ.

5.4. Ногоон бүс дэх айл өрх бүр гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл болон усны нөөц бэлтгэсэн байна.

5.5. Орон нутгийн Засаг дарга нь хүн ам төвлөрсөн сумын төв, тосгон, суурин газарт гал түймэр гарсан үед дуут дохио өгөх, дуудлага өгөх дараалал, авах арга хэмжээг зохион байгуулж, гал унтраах усны нөөц, ажиллах хүмүүсийн хуваарийг хийнэ.

Зургаа. Суурин газарт баримтлах аюулгүй байдлын шаардлага

6.1. Барилга байгууламж, барилга хоорондын гал эсэргүүцэх зайд тоног төхөөрөмж, чингэлэг, эд зүйл байрлуулж ашиглахыг хориглоно.

6.2. Тээврийн хэрэгслийн зогсоолд ил гал гаргах, хог шатаах, чингэлэг байрлуулахыг хориглоно.

6.2. Гал унтраах автомашин, техник хэрэгсэлд зориулагдсан талбайг тээврийн хэрэгслийн зогсоолын зориулалтаар ашиглахыг хориглоно.

6.3. Барилга байгууламж болон орон сууц, бусад барилгын хооронд төлөвлөгдсөн галын аюулгүйн зайд байгаа шатамхай хог хаягдлыг тухайн талбайг хариуцсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухай бүр нь цэвэрлэнэ.

6.4. Барилга байгууламж, объектоос 50 метрийн зайнд хог хаягдал шатаахыг хориглоно. Хүн ам төвлөрсөн суурин газар болон ойн захаас 100 метрийн зайд шатамхай эд зүйлийг хараа хяналтгүй орхих, ил галын тусламжтай халж хөөрдөг хэрэгсэл ашиглахыг хориглоно.

6.5. Гэр хорооллын гудамж, айл өрх нь хороо, багийн хэмжээнд жигдэрсэн харагдахуйц хаягжилттай байх бөгөөд гудамж хооронд галын автомашин чөлөөтэй зорчих, байрлах зайтай байна.

6.6. Мухар гудамж зайлшгүй гаргасан тохиолдолд төгсгөлдөө галын автомашин чөлөөтэй эргэх 15x15м талбай гаргана.

6.7. Гэр хороололд шатах шингэн, хий ашигласан үйлдвэрлэл явуулахыг хориглоно.

6.8. Гэр байшин, гэр хоорондын зай 5м–ээс дээш байна.

6.9. Пийшин зуухыг галлах үед галын аюулгүй байдлыг хангахдаа Барилгын зураг төсөл боловсруулах барилгын норм ба дүрэм “Халаалт агаар сэлгэлт ба кондиционер” (БНбД41-01-11)-ийг мөрдөнө.

6.10. Галлагааны улирлын өмнө зуух, пийшин, уурын зуух зэрэг дулаан үүсгэгч хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, илэрсэн гэмтлийг арилгасан байна.

6.11. Цахилгаан тоног төхөөрөмжийг угсарч ашиглахдаа БД 43-101-03 “Цахилгаан байгууламжийн дүрэм”-ийг мөрдөнө.

6.12. Гэр хорооллын айл, өрх үнс нурмаа ухаж бэлтгэсэн хаалт, таглаа бүхий нүхэнд асгана.

6.13. Өвсний хашаа, малын байранд ил гал гаргах, тамхи татахыг хориглоно.

6.14. Өрх бүр гал гарсан үед ашиглах багаж хэрэгсэлтэй байна. (гал унтраагуур, хүрз, хувин, дэгээ, эсгий, цохиур г.м)

Долоо. Гал түймрээс хамгаалах үйлчилгээ

7.1. Аж ахуйн нэгж, байгууллагад гал түймрээс хамгаалах үйлчилгээг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас олгосон эрх бүхий хуулийн этгээд явуулна. Гал түймэртэй тэмцэх, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалтыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага явуулна.

7.2. Гал түймрээс хамгаалах үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн ажилтан нь дараах агуулга бүхий галын аюулгүй байдлын сургалтад хамрагдсан байна:

7.2.1. инженер, техникч, удирдах ажилтны сургалтад:

7.2.1.1. аж ахуйн нэгж, байгууллагын галын аюулгүй байдлын системийн тогтолцоог бүрдүүлэх асуудал;

7.2.1.2. аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах, гал түймэр унтраах төлөвлөгөө боловсруулах аргачлал;

7.2.1.3. объектын гал түймрийн аюулын үнэлгээ хийх аргачлал;

7.2.1.4. галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон норм, нормативын баримт бичгийг хэрэгжүүлэх;

7.2.1.5. гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн ажиллагааны зарчим, ашиглалтын явцын техник үйлчилгээ, хяналтын зохион байгуулалт.

7.2.2. ажилтан, албан хаагчдын сургалтад:

7.2.2.1. гал түймрийн тухай ойлголт;

7.2.2.2. тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байгууллага, объектын галын аюулгүй байдлын дүрэм;

7.2.2.3. гал түймэр унтраах тоног төхөөрөмжийн ашиглалт, бэлэн байдлын хяналт, үйлчилгээ ;

7.2.2.4. гал түймэр гарсан тохиолдолд аврах үйл ажиллагааны зохион байгуулалт;

7.2.2.5. гал түймэр гарсан үед өөрийгөө болон бусдыг аврах үйл ажиллагааны мэдлэг;

7.2.2.6. барилга байгууламж, объектын галын аюулгүй байдлын норм, дүрмийн талаарх ойлголт;

7.2.2.7. гал унтраах шуурхай төлөвлөгөөний талаарх мэдлэг;

7.2.2.8. гал түймрээс аврах үйл ажиллагаа, гал унтраах анхан шатны багаж, төхөөрөмжтэй ажиллах дадлага, туршлага.

7.3. Гал түймрээс хамгаалах үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжтэй байх бөгөөд уг тоног төхөөрөмжид техникийн үйлчилгээ болон галын аюулгүй байдлын хяналт хийж, энэ дүрмийн 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бүртгэнэ.

Найм. Барилга байгууламжийг гал унтраах анхан шатны багаж, хэрэгслээр хангах

8.1. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн төрөл, хэмжээг шатах бодисын физик-химийн болон галын аюулын шинж чанар, тэдгээрийн гал унтраах бодистой үйлчлэх харилцан үйлчлэл зэргийг харгалзан тодорхойлно.

8.2. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, гал унтраагуурыг дахин цэнэглэх, хэрэгсэл нэг бүрийг хяналтын карттай болгох, үзлэг хийх, хяналт тавих асуудлыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага хэрэгжүүлж, хяналт, бүртгэлийн хуудсанд тэмдэглэгээ хөтөлнө.

8.3. Аж ахуйн нэгж, байгууллага бүр өөрийн барилга байгууламж, объект бүрийг шаардлагатай тоо хэмжээний, бүрэн ажиллагаатай гал унтраагуураар хангана. Барилга байгууламжид байрлуулах гал унтраагуурын тоо, төрлийг тухайн барилга байгууламжийн талбайн хэмжээ, галын ангилал, гал унтраагуурын унтраах хүчин чадал зэргийг харгалзан энэ дүрмийн 1, 2 дугаар хавсралтад заасан үзүүлэлтэд нийцүүлэн сонгоно.

8.4. Барилга байгууламжид суурилуулсан гал унтраагуур бүр техник бүртгэлийн паспорт, гарал үүслийн гэрчилгээ, дугаартай байна. Гал унтраагуурын түгжээг нэг удаагийн лацаар лацадсан байна.

8.5. Гал унтраагуурын нэг удаагийн лац дээр дараах тэмдэглэгээг хавсаргана:

8.5.1. лацны хувийн дугаар;

8.5.2. гал унтраагуурыг цэнэглэсэн огноо.

8.6. Дараах ангилалын галыг дор дурдсан нунтаг гал унтраагуураар унтраахад тохирох цэнэгээр цэнэглэнэ:

8.6.1. галын А ангилалд – АВСЕ нунтаг

8.6.2. галын В,С,Е ангилалд – АВСЕ, эсхүл ВСЕ нунтаг

8.6.3. галын D ангилалд – D нунтаг

8.7. 50мкв-аас доош талбайтай орон сууц, барилгын тасалгаанд зөөврийн болон өөрөө ажилладаг, эсхүл эдгээртэй ижил төстэй нунтаг гал унтраагуур ашиглаж болно.

8.8. Барилга байгууламж, объектийн гал түймэр гарч болзошгүй аюултай хэсгийн хэмжээнээс хамаарч хөдөлгөөнт, эсхүл зөөврийн гал унтраагуурыг байрлуулна.

8.9. Барилга байгууламжид байрлуулах гал унтраагуурыг сонгохдоо гал унтраагуурын хэвийн ажиллагааны хэм нь барилга байгууламжийн өрөө тасалгааны хэмтэй нийцсэн байх шаардлагатай.

8.10. Хоёр, түүнээс дээш галын ангилал бүхий өрөө тасалгаанд олон зориулалтын гал унтраагуурыг (нунтаг гал унтраагуур) ашиглана.

8.11. Олон нийтийн барилга байгууламжийн давхар бүрт 2-оос дээш бага, дунд оврын гал унтраагуурыг байрлуулна.

8.12. Үйлдвэрлэлийн тэсрэх болон галын аюулын D ангиллын өрөө тасалгааны талбайн хэмжээ нь 100 мкв-аас бага тохиолдолд гал унтраагуурыг төлөвлөхгүй байж болно.

- 8.13. Гал унтраагуурыг цэнэглэх чиг үүрэг бүхий хуулийн этгээд гал унтраагуурыг зохих техникийн үзүүлэлтийн дагуу цэнэглэж, энэ талаар баталгааны хуудас, паспортод тэмдэглэл хийж, тухайн байгууллагад хүргүүлнэ.
- 8.14. Архив, музей болон мэдээллийн технологийн техник, тоног төхөөрөмж бүхий барилгад хадгалагдаж байгаа эд зүйл, техник, тоног төхөөрөмжийн гал унтраах бодистой харилцан үйлчлэх нөхцөлийг тооцон хладон, эсхүл нүүрс хүчлийн хийн гал унтраагуурыг байрлуулна.
- 8.15. Хамгаалах талбайн гал түймэр гарах боломжит хэсгээс гал унтраагуур хүртэлх зайг олон нийтийн барилга байгууламжид 20метр, тэсрэх болон галын аюулын А, Б, В ангиллын барилгад 30 метр, Г ангиллын барилгад 40 метр, Д ангиллын барилгад 70 метрээс тус тус ихгүй байхаар тооцно.
- 8.16. Гал унтраах автомат тоног төхөөрөмжөөр тоноглогдсон барилга байгууламжид байрлуулах гал унтраагуурын тоог энэ дүрмийн 1, 2 дугаар хасвралтад заасан гал унтраагуурын 50 хувиар тооцож байрлуулна.
- 8.17. Барилга байгууламжийн гадна байрлах галын гидрант, галын шат, гал унтраах багаж хэрэгсэл шөнийн цагт ашиглахад зориулсан гэрэлтүүлэгтэй байна.
- 8.18. Гал унтраах усан хангамжийн сүлжээ нь байнгын ажиллагаатай галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичигт заасан гал унтраах усны нөөцтэй байна.
- 8.19. Гал унтраах усан хангамжийн сүлжээний ажиллагааг жилд хоёроос доошгүй удаа (хавар, намар) шалгаж, уг үйл ажиллагааг баримтжуулна.
- 8.22. Гал түймэр унтраах усан хангамжийн эх үүсвэрт жилийн аль ч улиралд саадгүй очих зам, гарцтай байна.
- 8.23. Гал түймэр унтраах усан хангамжийн эх үүсвэрт (гидрант, усан сан г.м) очих чиглэлийг гэрэлтэх тэмдэг, тэмдэглэгээгээр хийх бөгөөд тэдгээрийг ил харагдах газар байрлуулна. Гэрэлтэх тэмдэг, тэмдэглэгээгээр усны эх үүсвэрт очих чиглэлийг зааж, хүрэх зайг тодоор бичсэн байна.
- 8.24. Барилгын гадна, доторх гал түймэр унтраах усны сүлжээг хаах, даралтыг бууруулах тохиолдолд энэ талаар гал унтраах анги, гал түймрийн улсын хяналтын байцаагчид мэдэгдэнэ.
- 8.25. Барилгын гадна галын гидрантыг байнга бэлэн байдалд байлгаж, өвөл хөлдөхөөс хамгаалан дулаалж цэвэрлэсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшлийн талбайн 50 м доторх гадна галын гидрантын бүрэн бүтэн байдалд хяналт тавина.
- 8.26. Гал түймэр унтраах ус шахах хөөрөгний цахилгаан хөдөлгүүр нь тэжээлийн тасралтгүй хангамжтай байна.

8.27. Барилгын доторх галын гидрант (галын кран) нь байнгын даралттай, стандартад нийцсэн хайрцаг сав, хоолой, хушуутай байна. Хоолой нь усны шугам, галын хушуунд холбоотой байх бөгөөд эвхэлтийг жилд 1-ээс доошгүй удаа солино. Галын усны шугам, хоолойны холбох хэрэгсэл нь гал унтраах ангийн автомашин, багаж хэрэгслийг залган ажиллуулахад саадгүй байх шаардлагатай.

8.28. Галын усны хөөргийн станцын өрөөнд гал унтраах усан хангамжийн ерөнхий схем зураг, ус шахах хөөрөгний хүчин чадлыг тусгасан зааврыг байрлуулсан байна. Галын усны хөөрөг дээр түүнийг ажиллуулах дарааллын зааврыг тодорхой байрлуулсан байна.

8.29. Галын усны хөөргийн станцын байгууламж нь гал түймэр унтраах, аврах ангитай шууд холбогдох телефон утсан холбоотой байна.

8.30. Ус хэмжих төхөөрөмжийн буцах шугам дээр суурилуулсан цахилгаан хаалтыг жилд хоёроос доошгүй удаа, галын хөөргийг сар тутам шалгана. Эдгээр тоног төхөөрөмж нь байнгын ажиллагаатай байна.

8.31. Объектын нутаг дэвсгэрт, эсхүл түүний орчимд (200м дотор) байгалийн болон хиймэл усны эх үүсвэр (усан сан, нуур, цөөрөм г.м) байгаа бол галын автомашинд зориулсан 12х12м хэмжээтэй эргэх талбайтай хатуу хучилттай замтай байна.

8.32. Усан хангамжийн эх үүсвэр, хиймэл нуур, цөөрөм, гадна галын гидрантыг орон нутгийн Засаг дарга тодорхой байгууллага, аж ахуйн нэгжид хариуцуулна.

8.33. Усан хангамжийн гүний худгийг (цамхгийг) аль ч улиралд галын автомашинд ус өгөх боломжтой байдлаар тоногложсон байна.

8.34. Гал унтраах усны нөөцийг ахуйн болон үйлдвэрийн зориулалтаар ашиглахыг хориглоно.

8.35. Усан цэнэгтэй гал унтраагуурыг өвлийн улиралд (+1 0С-ээс бага хэмд) дулаан байранд хадгална.

8.36. Барилга байгууламжийн хонгилд байрлуулсан гал унтраагуур нь хүмүүсийг аюулгүй нүүлгэн шилжүүлэх (аврах) ажиллагаанд саад учруулахааргүй байх бөгөөд гал унтраагуурыг гарцны ойролцоо, ил харагдах газарт шалны түвшингээс 1,5 м-ээс ихгүй өндөрт байрлуулна.

8.37. Үйлдвэрийн болон агуулахын барилга байгууламж нь галын усан хангамж, гал унтраах автомат систем төлөвлөгдөөгүй, эсхүл үйлдвэрийн нутаг дэвсгэрт гадна галын усан хангамжгүй, эсхүл тухайн байгууллагын барилга байгууламж, гадна технологийн тоног төхөөрөмж нь гадна галын усан хангамжаас 100м-ээс хол зайд байрладаг бол гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн бүрдэл (галын сарай) төлөвлөнө.

8.38. Энэ дүрмийн 8.37-д заасан барилга байгууламжид шаардлагатай гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн бүрдлийн тоо, төрлийг барилга байгууламж, өрөө тасалгааны

болон гадна технологийн тоног төхөөрөмжийн тэсрэх болон галын аюулын ангиллаас хамаарч мөн дүрмийн 3 дугаар хавсралтад заасан нормын дагуу төлөвлөнө.

8.39. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн бүрдлийг энэ дүрмийн 4 дүгээр хавсралтад заасан нормын дагуу гал унтраах багаж болон бусад хэрэгслээр тоногдосон байна.

8.40. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн бүрдлийн ойролцоо 0,2 м³-ээс дээш эзэлхүүнтэй ус хадгалах савыг 2-оос доошгүй хувингийн иж бүрдлийн хамт байруулна. Элсний хайрцаг нь 0,5 м³ эзэлхүүнтэй, хур тундаснаас хамгаалсан хэрэглэхэд хялбар байрлалд хүрзний иж бүрдэлтэй байна.

8.41. Хялбар авалцан асах шингэн, шатах шингэн асгарч болзошгүй задгай талбай болон өрөө тасалгаанд галын сарайны хамт элстэй хайрцаг байрлуулна.

8.42. Тэсрэх болон галын аюулын А, Б, В ангиллын барилга байгууламж, гадна технологийн тоног төхөөрөмж байрласан хэсэгт 500 м² тутамд 0,5м³, Г, Д ангиллын барилга байгууламж, гадна технологийн тоног төхөөрөмж байрласан хэсэгт 1000 м² тутамд 0,5м³ нөөц элстэй хайрцаг, хүрзний иж бүрдлийг тус тус байрлуулна.

8.43. Гал түймрийн дөл, дулааны үйлчлэлээс тусгаарлах шатдаггүй тусгаарлагч хучлагын урт, өргөн нь 1 м-ээс дээш байна.

8.44. Хялбар авалцан асах шингэн, шатах шингэн хадгалдаг, ашигладаг барилга байгууламжид 2х1,5 м-ээс дээш хэмжээтэй гал түймрийн дөл, дулааны үйлчлэлээс тусгаарлах шатдаггүй тусгаарлагч хучлага байна.

8.45. Хучлагыг ус үл нэвтрүүлэх ууттай байлгах бөгөөд гал түймрийн үед хурдан хэрэглэх боломжтой байдлаар байрлуулна.

8.46. Гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, тусгайлан бэлтгэсэн тамхи татах цэгт галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн дагуу хийгдсэн таних тэмдэг байрлуулан тухайн цэгт нэвтрэх замыг хаахыг хориглосон тэмдэг, тэмдэглэгээ тавьсан байна.

8.47. Гал унтраах автомат систем, дохиолол, утаа зайлуулах систем, гал гарсан тохиолдолд мэдээлэх дуут болон гэрлэн дохионы зураг төсөл, угсралт, ашиглалт, үйлчилгээг гал түймрээс хамгаалах үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд батлагдсан зураг төсөл, төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

8.48. Гал унтраах автомат систем, дохиолол, утаа зайлуулах систем, гал гарсан үед мэдээлэх дуут болон гэрлэн дохио, аврах зам, гарцын гэрлэн дохио, хаалга, зам гарц, аврах үйл ажиллагааны техник хэрэгслийг техникийн үндсэн бичиг баримтад тусгасан засвар үйлчилгээний хугацаа, үзлэгийн хуваарь, гэрээ, зөвшөөрлийн бичигт заасан хугацаанд техникийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг хийж, энэ талаар тэмдэглэл хөтөлнө.

8.49. Гал унтраах автомат систем, дохиолол, утаа зайлуулах систем, гал гарсан тохиолдолд мэдээлэх дуут болон гэрлэн дохиог улирал тутам шалгаж, зохих техникийн үйлчилгээг хийнэ.

8.50. Засвар, үйлчилгээ хийх зорилгоор дохиолол, галын системийг хэсэгчлэн салгах тохиолдолд байгууллагын удирдлага барилга байгууламж, өрөө тасалгааны галын аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

8.51. Галын хяналтын байранд гал унтраах автомат болон дохиоллын системийн зураг схем, гал гарсан дохио хүлээн авсан үед ажиллах журам, дохиолол ажилгүй болсон болон гэмтэлтэй үед авах арга хэмжээг тодорхой заасан зааврыг байрлуулсан байна.

8.52. Хяналтын байранд харилцах телефон утас, 3-аас доошгүй ослын гэрэлтүүлэг, зөөврийн гар чийдэн байрлуулсан байна.

8.53. Галын автомат системийг батлагдсан зураг төслийн дагуу хийж, бүрэн ажиллагаатай, байнгын бэлэн байдалд байлгана.

8.54. Автоматаар ажилладаг (асаах төхөөрөмж) галын дохиолол, мэдээллийн төхөөрөмжийг ашиглалтын баримт бичигт тусгайлан заагаагүй бол гараар ажиллах горимд шилжүүлж болохгүй.

8.55. Гал унтраах автомат системийн станцын өрөөнд сүлжээний нэгдсэн схем зураг, гал унтраах автомат төхөөрөмжийг ажиллуулах зааврыг байрлуулна.

8.56. Гал унтраах автомат системийн шугам хоолойн холболт бүр дээр хамгаалж байгаа өрөөний дугаар, шүршигч хушууны төрөл, шугамын дугаарыг тэмдэглэсэн байна.

8.57. Гал түймэртэй тэмцэх гэрээт анги болон хэсгийн гал унтраах зориулалтын автомашиныг галын депо, эсхүл тусгайлан бэлдсэн дулаан, цахилгаан, телефон холбоотой хатуу хучилттай шал, дулаалгатай хаалга зэрэг гал сөнөөгчдийн ажиллах нөхцөлийг бүрэн хангасан байранд байрлуулна.

8.58. Гал унтраах автомашинаас тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг авах, автомашиныг зориулалтын бусаар ашиглахыг хориглоно.

8.59. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг гал унтраах үйл ажиллагаанаас бусад зүйлд ашиглахыг хориглоно.

---oOo---

Галын аюулгүй байдлын үндсэн

дүрмийн 1 дүгээр хавсралт

Барилга байгууламжид байх зөөврийн (гар) гал унтраагуурын норм

(Шатахуун түгээх станцаас бусад)

| Барилга, өрөө тасалгааны галын аюулын ангилал | Хамгаалах талбайн хязгаар (м ²) | Галын анги | Гал унтраагуур (ширхэг) * | | | | | | | Агаар эмульсийн |
|---|---|------------|--|---|-----|------|---------------------------------|---|-----------------|-----------------|
| | | | Ус болон хөөсний (10 литр багтаамжтай) | Нунтаг (гал унтраах бодисын багтаамжийг килограммаар хэмжинэ) | | | Хладон (2 (3) литр багтаамжтай) | Нүүрсхүчлийн (гал унтраах бодисын багтаамж литрээр) | | |
| | | | | 2/2 | 5/4 | 10/9 | | 2/2 | 5(8) эсхүл 3(5) | |
| А,Б,В | 200 | А | 2++ | - | 2+ | 1++ | - | - | - | 1++ |
| | | В | 4+ | - | 2+ | 1++ | 4+ | - | - | 1++ |
| | | С | - | - | 2+ | 1++ | 4+ | - | - | 1++ |
| | | Д | - | - | 2+ | 1++ | - | - | - | 1++ |
| | | Е | - | - | 2+ | 1++ | - | - | 2++ | - |
| В | 400 | А | 2++ | 4+ | 2++ | 1+ | - | - | 2+ | 1++ |
| | | Д | - | - | 2++ | 1++ | - | - | - | 1++ |
| | | Е | - | - | 2++ | 1+ | 2+ | 4+ | 2++ | - |
| Г | 800 | В | 2+ | - | 2++ | 1+ | - | - | - | 2++ |
| | | С | - | 4+ | 2++ | 1+ | - | - | - | 2++ |
| Г, Д | 1800 | А | 2++ | 4+ | 2++ | 1+ | - | - | - | 4++ |
| | | Д | - | - | 2++ | 1++ | - | - | - | 4++ |
| | | Е | - | 2+ | 2++ | 1+ | 2+ | 4+ | 2++ | - |

| | | | | | | | | | | |
|----------------------------|-----|---|-----|----|-----|----|----|----|-----|-----|
| Олон нийтийн барилга | 800 | А | 4++ | 8+ | 4++ | 2+ | - | - | 4+ | 2++ |
| | | Е | - | - | 4++ | 2+ | 4+ | 4+ | 2++ | - |
| | | | | | | | | | | |

* Барилга байгууламжид дээрх 5 төрлийн гал унтраагуураас багтаамж, хүчин чадлыг нийцүүлэн сонгож хэрэглэнэ.

Тайлбар: 1. Нунтаг болон нүүрсхүчлийн хийн гал унтраагуур нь 2 өөр тэмдэглэгээтэй бөгөөд гал унтраах бодисын жингээр тооцож ашиглана.

2. “++” тэмдэглэгээ нь объектод санал болгож байгаа гал унтраагуурыг, “+” тэмдэглэгээ нь санал болгож байгаа гал унтраагуур байхгүй нөхцөлд ашиглаж болохыг, “-” тэмдэглэгээ нь объектод зөвшөөрөгдөхгүйг илэрхийлнэ.

Галын аюулгүй байдлын үндсэн
дүрмийн 2 дугаар хавсралт

Барилга байгууламжид байх хөдөлгөөнт (тэргэнцэртэй)

гал унтраагуурын норм

(Шатахуун түгээх станцаас бусад)

| | | | |
|----------|-----------|-------|-----------------------------|
| Барилга, | Хамгаалах | Галын | Гал унтраагуур (ширхэг) <*> |
|----------|-----------|-------|-----------------------------|

| өрөө тасалгааны галын аюулын ангилал | талбайн хязгаар (м ²) | ангилал | Хөөсний гал унтраагуур (100 л багтаамжтай) | Хосолмол гал унтраагуур (хөөс, нунтаг) (100 л багтаамжтай) | Нунтаг гал унтраагуур (100 л багтаамжтай) | Нүүрсхүчлийн гал унтраагуур (багтаамжийг литрээр илэрхийлнэ) | |
|--------------------------------------|-----------------------------------|---------|--|--|---|--|-----|
| | | | | | | 25 | 80 |
| А, Б, В | 500 | А | 1++ | 1++ | 1++ | - | 3+ |
| | | В | 2+ | 1++ | 1++ | - | 3+ |
| | | С | - | 1+ | 1++ | - | 3+ |
| | | Д | - | - | 1++ | - | - |
| | | Е | - | - | 1+ | 2+ | 1++ |
| В, Г | 800 | А | 1++ | 1++ | 1++ | 4+ | 2+ |
| | | В | 2+ | 1++ | 1++ | - | 3+ |
| | | С | - | 1+ | 1++ | - | 3+ |
| | | Д | - | - | 1++ | - | - |
| | | Е | - | - | 1+ | 1++ | 1+ |

*Барилга байгууламжид дээрх 4 төрлийн гал унтраагуураас багтаамж, хүчин чадлыг нийцүүлэн сонгож хэрэглэнэ.

Тайлбар: “++” тэмдэглэгээ нь объектод санал болгож байгаа гал унтраагуурыг, “+” тэмдэглэгээ нь санал болгож байгаа гал унтраагуур байхгүй нөхцөлд ашиглаж болохыг, “-” тэмдэглэгээ нь объектод зөвшөөрөгдөхгүйг илэрхийлнэ.

Галын аюулгүй байдлын үндсэн

дүрмийн 3 дугаар хавсралт

Барилга байгууламжид байх галын сарайн норм

| Барилга, өрөө тасалгааны үйл ажиллагааны зориулалт болон ангилал, эсхүл гадна технологийн тоног төхөөрөмжийн галын аюулын ангилал | Нэг галын сарайн хамгаалах талбайн хязгаар (м.кв) | Галын ангилал | Галын сарайн |
|---|---|---------------|--------------|
| А, Б ба В | 200 | А | ГС |
| | | В | ГС |
| | | Е | ГС |
| В | 400 | А | ГС |
| | | Е | ГС |
| Г ба Д | 1800 | А | ГС |
| | | В | ГС |
| | | Е | ГС |
| Хөдөө аж ахуйн тариалангийн анхан шатны боловсруулалтын үйлдвэрийн газрын задгай талбай болон барилга | 1000 | - | ГС-Х |
| Галтай ажил гүйцэтгэх төрөл бүрийн зориулалтын байр | - | А | Х |

* Галын сарайн тэмдэглэгээ:

(ГС-А) – галын А ангилалд зориулсан галын сарай

(ГС-В) – галын В ангилалд зориулсан галын сарай

(ГС-Е) – галын Е ангилалд зориулсан галын сарай

(ГС-ХААҮ) – Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн газрын галын сарай

(ХГС) – Хөдөлгөөнт галын сарай.

Галын аюулгүй байдлын үндсэн

дүрмийн 4 дүгээр хавсралт

Галын сарайн багаж хэрэгслийн иж бүрдлийн норм

| Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн нэр | Галын ангилал, галын сарайн төрлөөс хамааруулсан иж бүрдлийн норм | | | |
|---|---|----------------|----------------|---------|
| | ГС-А ангилал А | ГС-В ангилал В | ГС-Е ангилал Е | ГС-ХААҮ |
| 1. 10л багтаамжтай агаар хөөсний гал унтраагуур | 2+ | 2+ | - | 2+ |
| 10л (9кг) эсхүл | 1++ | 1++ | 1++ | 1++ |

| | | | | |
|---|----|----|----|----|
| 5л (4кг) багтаамжтай нунтаг гал унтраагуур | 2+ | 2+ | 2+ | 2+ |
| 5л (3кг) багтаамжтай нүүрсхүчлийн хийн гал унтраагуур | - | - | 2+ | - |
| 1. Царил | 1 | 1 | - | 1 |
| 2. Багор | 1 | - | - | 1 |
| 4.Модон бариултай дэгээ | - | - | 1 | - |
| 5.Хувин | 2 | 1 | - | 2 |
| 6.Цахилгаан утас огтлох хайч, резин гутал, дэвсгэр | - | - | 1 | - |
| 7.Шатдаггүй тусгаарлагч хучлага | - | 1 | 1 | 1 |
| 8. Хүрз (хумбан) | 1 | 1 | - | 1 |
| 9. Хүрз (дөрвөлжин) | 1 | 1 | 1 | 1 |
| 10. Өвсний сэрээ | - | - | - | 1 |
| 11. Жижиг тэргэнцэр | - | - | - | - |
| 12. Усны сав | | | | |
| 200л | 1 | - | - | 1 |
| 20л | - | - | - | - |
| 13. Элстэй хайрцаг 0.5м ³ | - | 1 | 1 | - |
| 14. Гар усны шахуурга | - | - | - | - |
| 15. 18-20мм диаметртэй 5м урт хоолой | - | - | - | - |
| Дулааны үйлчлэлээс хамгаалах 1,4х2м хэмжээтэй хаалт | - | - | - | - |
| Дулааны үйлчлэлээс хамгаалах хаалтны тулгуур, суурь | - | - | - | - |

Тайлбар: *Дотоодын хяналт шалгалт, төрийн хяналт шалгалт болон галын аюулгүй байдлын үнэлгээ хийх эрх бүхий хуулийн этгээд байж болно.